

14 хоногийн шуурхай мэдээ

Тус сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Морьт, Хонгор, Ажирхай, Өрнөлт багуудад гүн өрмийн худаг гаргах ажлыг бүлэг сонгон шалгаруулалтын журмаар зарлаж Эхний Эхэн ХХК-тай гэрээ байгуулан ажиллалаа.

2021 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн гүн өрмийн худгийг хүлээн авах комиссыг 5 хүний бүрэлдэхүүнтэй томилон гүйцэтгэлийг актаар хүлээн авлаа.

Аймгийн хөрөнгө оруулалтаар тус сумын нийтийн эзэмшлийн талбайд 1 га-д ойн зурвас байгуулах гэрээг байгуулж, Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Сум дундын ойн ангиас 1 га нь ойн зурвасыг хүлээн авах ажлыг зохион байгуулж, амьдын ургалтыг 75%-тай хүлээлгэн өглөө.

Говь-Угтаал сумын гэр бүлийн зөвлөлөөс хүүхэд бүрийн төлөө хариуцлагатай байя аянд нэгдэж ЗДТГазраас удирдамж боловсруулан батлуулж, байгууллагын албан хаагчдын гэр бүлийн дунд тэмцээн уралдаан, ёс зүйн дүрмийг танилцуулан, гэрээ байгуулах ажлыг зохион байгууллаа.

Эрүүл мэндийн төв

Голомтонд 4682 м2, урьдчилан сэргийлж 80м2 нийт 4762 м2 газарт ариутгал халдваргүйжүүлэлт хийгдлээ.

261 хүнд түргэвчилсэн оношлуураар шинжилгээ хийж эерэг гарсан 61иргэнийг хэвтэн эмчлүүлээ.

Ойрын хавтал 123, дан хавтал 35 нийт 158 иргэнийг гэрийн тусгаарлалтанд авч хяналт тавьж шинжилгээ хийж ажиллаа.

55 наснаас дээш, архаг хууч өвчтэй иргэний 2 ба 3 тунгийн вакциныг 80 хүнд, товллын вакциныг 106 хүүхдэд тус тус хийсэн.

Цэцэрлэг, байрны 60 хүүхдүүдэд цагаан хорхойны шинжилгээ хийсэн.

Ерөнхий боловсролын сургууль

Бага ангийн сурагчдаас гараа үнэлгээний шалгалт авлаа.

Сургуулийн сурагчдаас ковид өвчин гарсан тул багш нарын зөвлөл хуралдаж хичээл сургалтын үйл ажиллагааг цахимд шилжүүлэх санал гарган Сумын онцгой комисст хүргүүлэн 09.27н хүртэл цахимаар хичээллэн 09.27оос танхимын хичээл эхлүүлэхээр шийдвэрлүүлэн журмын дагуу ажиллаа.

БШУСайд, ЭМ-ийн сайдын хамтарсан тушаалын дагуу багш, ажилтан, сурагч, эцэг эхчүүдэд зориулсан зөвлөмжийг гарган байршууллаа.

Сурагчдын хоцрогдол арилгах ажлын дэвтрийг судлагдахуун тус бүрээр хэвлэн гарган 1-9р ангийн сурагчдад хүргүүлэн ажиллаж байна.

Сургуулийн дотор гадна анги танхимуудад цэвэрлэгээ үйлчилгээ хийн, ариутгал халдваргүйжүүлэлтийг хийлгэлээ.

Засаг даргийн захирамжаар 2021 оны 09 сарын 14-27-ны өдөр хүртэл хязгаарлах дэглэмтэй холбогдуулан эцэг эх асран хамгаалагчидтай холбогдон цахим хичээл 2-3 хийж Говь-Угтаал Хүүхдийн цэцэрлэгт байршууллаа .

Хүүхдийн цэцэрлэг

09 сарын 14-15ний хооронд 2-3 настай хүүхдүүдийг багш нар сувилагч Батзолтой хамтран томуугийн вакицинд хамрууллаа .

09сарын 27 ноос эхлэн бүлгийн хүүхдүүдээ хүлээн авч хэвийн ажиллаж байна
Ковид -19 –өөр өвдсөн хүүхэдгүй байна .

ТАЙЛАН БИЧСЭН

АРХИВ,БИЧИГ ХЭРГИЙН ЭРХЛЭГЧ

Г.АМАРБАЯР

ХЯНАСАН

ЗДТГАЗРЫН ДАРГА

Н.ӨЛЗИЙТОГТОХ

14 хоногийн шуурхай мэдээ

ОНХС-ийн хөрөнгөөр Цамхагт гэрэл 12.000.000 төгрөг, Өвс тэжээлийн фондны хашаа барих 15.000.000 төгрөгийн төсөвт өртөгтэй ажлууд тус тус зарлагдаад байна. Нөхөрлөл болон бүлгүүдээс үнийн санал ирүүлэхийг уриалан ажиллаж байна.

Хөдөө аж ахуйн чиглэлээр

Хүнсний мэдээг аймгийн хөдөө аж ахуйн газрын хүнс хариуцсан мэргэжилтэнд 7 хоног бүрийн 1 дэхь өдөр, Отор, өвс тэжээлийн нөөцийн мэдээг 7 хоног бүрийн 3 дахь өдөр тогтмол гарган ажиллаж байна.

Зах зээл ба бэлчээр удирдлага төслийн хүрээнд Хаан банкт хамтран хэрэгжүүлж байгаа иргэн аж ахуй нэгжид зээл олгох мэдээллийг 4 аж ахуй нэгж 36 иргэнд танилцуулан ажиллаа мөн 7 иргэний материал аймгийн Хаан банканд зээлийн судалгаанд бүртгэгдээд байна.

Сум хөгжүүлэх сангийн зээлийн мэдээллийг монголбанкны зээлийн мэдээллийн санд сар бүр цаг хугацаанд нь холбогдож бүрэн шинчлэл хийлгэж сангийн мэдээлэл дамжуулан ажиллаа.

Ургамал судлалын хүрээнд орон нутгийн бэлчээрийн талхлалт болон бэлчээрийн даац хэтрэлтийн мэдээллийн цаг уурын байгууллага, багийн дарга нартай хамтран гаргаж тус ажлын хүрээнд улсын төсвийн хөрөнгөөр тус ажил хэрэгжиж аймаг сумын засаг даргын захирамж ажлын хэсэг гарч тус сард бүрэн ажил хийгдэж дуусхаар 11 ажлын хэсэг гараад ажиллаж байна.

9-10 сарын хугацаанд өвөлжилт, отор нүүдэл, өвс тэжээлийн нөөц бүрдүүлэлт цаг хугацаатай тайлан мэдээг гарган ажиллаж байна.

Мал эмнэлгийн чиглэлээр

2021 онь 09 сарын 8-ны өдөр малын гоц халдварт шүлхий өвчин оншлогдож 28 хоногийн хорио цээрийн дэглэм тогтоож сүүлийн 10 хоногт мал нэмэж өвчлөөгүй тул 2021 оны 10 сарын 6-ны өдөр хорио цээрийн дэглэмийг хязгаарлалтын дэглэм болгон бууруулсан. Мөн мал амьтаныг бруцеллёз өвчнөөс сэргийлэх стратик төлөтлөгөөний дагуу хийгдсэн дархлаажуулалтын ажил дуусаж 238 тугал, 20223 хурга, 8192 ишиг хийт 28415 малыг хамруулан ажилаад байна. Галзуу өвчний дархлаажуулалтын ажил эхлээд явж байна.

Хүүхдийн цэцэрлэг

Танхимаар бүлгийн хүүхдүүдээ авч хэвийн үйл ажиллагаагаа явуулж байна. Өвдсөн хүүхэд байхгүй байна.

5 настай 22 хүүхдүүдэд Дасгал ажлын ном гарын авлага Г.Мөнхсоёл багш эцэг эхчүүдэд тарааж өглөө.

Дундговь аймгийн цагдаагийн хэлтэсээс зохион байгуулж буй “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” ажлын хүрээнд байгууллага дээр Аав цагдаа, “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх самбар” байршуулах зэрэг үйл ажиллагааг зохион байгууллаа.

Байгууллагуудад аялаж яваа “Хүүхэд бүрийн төлөө хариуцлагатай байя” аяны хүрээнд багш ажилчидтай Хүүхэд хамгааллын ёс зүйн дүрмийн гэрээ байгуулах, мөн Миний гэр-Аюулгүй орчин хяналтын хуудсаар үнэлгээ хийлээ.

Бэлтгэл бүлгийн хүүхдүүдэд дунд чөлөөт сэдвээр “АХА” тэмцээн зохион байгууллаа.

Хүүхдийг Ивээх Сангаас Японы жүжигчин Дийн Фужиокагийн цуглуулсан хандиваар хэрэгжүүлж буй ном, тоглоомын багцыг Эрхлэгч А.Алтанчимэг хүлээж авлаа.

Ерөнхий боловсролын сургууль

Монголын багш нарын 55, Дэлхийн багш нарын 27 дахь баярын өдрийг тохиолдуулан жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг “Сурагчийн нэг өдөр” үйл ажиллагааг зохион байгууллаа.

Судлагдахуун бүрээр бүх ангийн сурагчдад “Хоцрогдол арилгах дасгал ажлын дэвтэр”ийг удаа дараалан хэвлэн тараах ажлыг зохион байгуулж байна. мөн багш цахим хичээлийг бэлтгэн ангиудын цахим бүлгэмээр холбогдон хичээлээ зааж байна.

Сургуулийн халаалтын сантехникийн засварын ажил хийгдэж байна.

Сургуулийн эд хөрөнгийн тооллогыг ажлын хэсэг нүд үзэн тоолон баталгаажууллаа

Аймгийн хэмжээнд хэрэгжиж буй “Хүүхэд бүрийн төлөө хариуцлагатай байя” аянд нэгдэж хамт олны эцэг эхийн зөвлөлийг шинэчлэн байгуулж аяны хүрээнд 5 ажлыг төлөвлөн зохион байгуулж ажиллаа

Боловсролын мэдээллийн системд сурагчдын болон багш нарын мэдээллийг шинэчиллээ

Цахим хичээлийн үед багш ажилчдын өөрийгөө хөгжүүлэх сургалтын цагийн хуваарийг гарган “Үндэсний бичиг”, “Мэдээлэлзүй”, “Багш хөгжлийн цаг” зэрэг сургалтуудыг явуулж байна.